

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гадаад харилцааны яамны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** СНАГ-2023/127/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2023 он</p>	<p>Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: П.Чанцалдулам Утас: 261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Ахлах аудитор: И.Эрдэнэцэцэг Утас: 261628 Цахим хаяг: erdenechimegi@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Н.АНХБАЯР ТАНАА

2023.02.17 № 07/272  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гадаад харилцааны яамны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гадаад харилцааны яамны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Дэлхий нийтийг хамарсан “Ковид-19” цар тахлын нөхцөл байдал харьцангуй намжиж, Засгийн газар “гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын горим”-ыг 2022 оны 2 дугаар сард цуцалсантай холбогдуулан ГХЯ бизнес, эдийн засгийн үйл ажиллагааг идэвхжүүлэхэд нэн чухал ач холбогдолтой хилийн боомтын үйл ажиллагаа, экспорт, импортыг идэвхжүүлж, иргэд зорчих нөхцөлийг сэргээхийн зэрэгцээ, иргэдэд мэдээ зөвлөмж түгээх, үйлчилгээг чирэгдэлгүй хүргэх, гадаад сурталчилгааг эрчимжүүлэхэд анхааран ажиллаж байна.

### Аудитын гол асуудал

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу яамны цахим хуудсанд байгууллагын үйл ажиллагаа, төв аппаратын ажилтнуудын чиг үүрэг, хариуцах ажлын талаарх зэрэг хуулиар заасан мэдээллийг байршуулж, яам, системийн байгууллагуудын мэдээллийн сүлжээ, интернэт, цахим шуудангийн серверийн аюулгүй байдал, байнгын хэвийн ажиллагааны нөхцөлийг бүрдүүлэн, яамны хэмжээнд ашиглагдаж буй программ хангамжийн аюулгүй байдлыг лиценз бүхий программуудаар хангах хүрээнд тоног төхөөрөмж, программ хангамжийг 618.6 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

## Бусад асуудлын хэсэг

Гадаад харилцааны яамны жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 54 зорилтын хүрээнд 231 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 88.24 хувиар дүгнэсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ



## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)</b>	<b>380,815,650.02</b>	<b>1,178,557,500.41</b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>4,246,191.00</b>	<b>5,366,191.00</b>
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
31110	Төгрөг	-	-
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	4,246,191.00	5,366,191.00
31210	Төгрөг	4,246,191.00	5,366,191.00
31211	Төрийн сангийн харилцах	4,237,191.00	4,237,191.00
3121109	Техник хяналт - 900016370	4,237,191.00	4,237,191.00
31213	Ажилжааны банкин дахь харилцах	9,000.00	1,129,000.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>63,964,750.11</b>	<b>546,145,360.00</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	924,784.41	-
33102	НДШ-ийн авлага	924,784.41	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	42,839,907.50	540,151,604.00
33500	Бусад авлага	20,200,058.20	5,993,756.00
33510	Байгууллагаас авах авлага	8,075,855.00	-
335113	Бусад зардлын тооцооны авлага	8,075,855.00	-
33520	Хувь хүмүүсээс авах авлага	12,124,203.20	5,993,756.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>6,650,000.00</b>	<b>196,500,000.00</b>
34600	Урьдчилж гарсан зардал	6,650,000.00	196,500,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>305,954,708.91</b>	<b>430,545,949.41</b>
35100	Түүхий эд материал	190,520,435.60	302,367,767.30
35110	Тусгай зориулалттай материал	190,520,435.60	302,367,767.30
35400	Хангамжийн материал	115,434,273.31	128,178,182.11
35410	Бичиг хэргийн материал	525,000.00	-
35470	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	84,224,984.31	94,113,759.11
35490	Бусад хангамжийн материал	30,684,289.00	34,064,423.00
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)</b>	<b>10,298,020,925.62</b>	<b>9,725,060,572.21</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>10,298,020,925.62</b>	<b>9,725,060,572.21</b>
39200	Биет хөрөнгө	8,313,965,502.37	8,505,870,015.05
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,610,008,368.55	8,020,074,674.55
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	(523,242,180.67)	(742,056,042.90)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	3,643,243,550.03	4,225,486,713.27
3920501	Машин тоног төхөөрөмж(компьютер)	3,141,531,297.81	3,607,481,407.05
3920502	Машин тоног төхөөрөмж(Холбооны)	501,712,252.22	618,005,306.22
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(3,157,180,131.15)	(3,463,881,045.10)
3920601	Хуримтлагдсан элэгдэл -(компьютер)	(2,713,191,646.35)	(3,000,762,215.73)
3920602	Хуримтлагдсан элэгдэл -(Холбооны)	(443,988,484.80)	(463,118,829.37)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,445,120,100.86	1,465,911,530.86
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(995,852,713.25)	(1,094,064,024.63)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	86,193,135.00	86,193,135.00
39216	Дуусаагүй барилга, байгууламж	5,197,470,299.00	-
39217	Номын фонд	8,205,074.00	8,205,074.00
39300	Биет бус хөрөнгө	1,984,055,423.25	1,219,190,557.16
39301	Програм хангамж	1,156,083,676.00	503,890,076.00
39302	Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж	(147,516,252.75)	(260,187,518.84)
39303	Бусад биет бус хөрөнгө	975,488,000.00	975,488,000.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)</b>	<b>10,678,836,575.64</b>	<b>10,903,618,072.62</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)</b>	<b>8,697,546.34</b>	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	8,697,546.34	-

41300	Өглөг	8,697,546.34	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	548,689.31	-
413103	ХАОАТ-ын өглөг	548,689.31	-
41360	Бусад өглөг	8,148,857.03	-
41361	Байгууллагад төлөх өглөг	8,148,857.03	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)</b>	<b>10,670,139,029.30</b>	<b>10,903,618,072.62</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	10,670,139,029.30	10,903,618,072.62
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,330,370,602.25	3,330,370,602.25
51200	Хуримтлагдсан үр дүн	6,444,679,642.42	6,678,158,685.74
51210	Өмнөх үеийн үр дүн	6,444,679,642.42	6,444,679,642.42
51220	Тайлант үеийн үр дүн	-	233,479,043.32
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	895,088,784.63	895,088,784.63
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)</b>	<b>10,678,836,575.64</b>	<b>10,903,618,072.62</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>13,130,345,541.28</b>	<b>14,525,778,461.43</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>493,835,292.50</b>	<b>931,087,493.00</b>
1200	Өмчийн орлого	493,835,292.50	931,087,493.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	493,835,292.50	931,087,493.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	476,179,727.12	929,643,293.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	17,655,565.38	1,444,200.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>12,636,510,248.78</b>	<b>13,594,690,968.43</b>
1310	Улсын төсвөөс	8,745,654,803.00	10,123,426,356.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	8,745,654,803.00	10,123,426,356.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,890,855,445.78	3,471,264,612.43
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	950,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	3,731,478,249.78	2,425,301,955.93
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	159,377,196.00	95,962,656.50
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>13,290,435,644.03</b>	<b>14,292,299,418.11</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,290,435,644.03	13,780,332,294.85
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,132,548,671.24	9,536,752,463.39
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	3,494,486,571.36	3,593,942,343.88
210101	Үндсэн цалин	3,494,486,571.36	3,593,942,343.88
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	462,104,039.18	454,848,633.95
210201	Нийгмийн даатгалын шимтгэл	462,104,039.18	454,848,633.95
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	187,140,540.17	187,255,298.64
210301	Гэрэл, цахилгаан	76,058,347.79	85,983,072.51
210302	Түлш, халаалт	94,790,390.38	77,525,652.13
210303	Цэвэр, бохир ус	16,291,802.00	23,746,574.00
2104	Хангамж, бараа материалын зардал	173,133,364.83	183,779,739.66
210401	Бичиг хэрэг	54,068,433.94	54,872,427.00
210402	Тээвэр, шатахуун	41,043,057.03	42,681,756.51
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	60,557,743.86	82,684,760.15
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,999,350.00	2,750,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,464,780.00	790,796.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	30,859,546.30
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	56,102.00
210604	Урсгал засвар	-	30,803,444.30
2107	Томилолт, зочны зардал	557,502,710.11	1,027,435,145.26
210701	Гадаад албан томилолт	485,189,123.01	802,977,102.08
210702	Дотоод албан томилолт	10,312,628.00	6,592,176.15
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	62,000,959.10	217,865,867.03

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	348,251,119.97	547,822,321.83
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	311,029,064.97	498,329,537.83
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	14,554,400.00	2,374,759.00
210807	Газрын төлбөр	22,667,655.00	47,118,025.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,909,930,325.62	3,510,809,433.87
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,899,129,921.73	2,601,931,303.48
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	7,240,000.00	2,447,900.00
210914	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,003,560,403.89	906,430,230.39
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,157,886,972.79</b>	<b>4,243,579,831.46</b>
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	877,575,471.10	1,217,866,642.39
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	877,575,471.10	1,217,866,642.39
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	389,044,511.12	734,080,001.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	389,044,511.12	734,080,001.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	189,075,602.50	78,969,944.12
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	10,680,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	120,232,992.50	42,828,444.12
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	42,155,410.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	26,687,200.00	25,461,500.00
21310	Засгийн газрын дотоод шилжүүлэг	1,702,191,388.07	2,212,663,243.95
213102	Тусгай зориулалтын шилжүүлэг	1,702,191,388.07	2,212,663,243.95
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	511,967,123.26
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	-	511,967,123.26
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	511,967,123.26
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)</b>	<b>(160,090,102.75)</b>	<b>233,479,043.32</b>
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	-
<b>6</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)</b>	<b>(160,090,102.75)</b>	<b>233,479,043.32</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>13,364,633,209.90</b>	<b>15,063,029,812.20</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>476,179,727.12</b>	<b>930,003,552.20</b>
1200	Өмчийн орлого	476,179,727.12	930,003,552.20
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	476,179,727.12	930,003,552.20
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	476,179,727.12	930,003,552.20
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>12,888,453,482.78</b>	<b>14,133,026,260.00</b>
1310	Улсын төсвөөс	8,745,654,803.00	10,123,426,356.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	8,745,654,803.00	10,123,426,356.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,142,798,679.78	4,009,599,904.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	163,072,900.00	992,839,907.50
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	3,732,715,583.78	2,807,491,880.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	87,633,000.00	113,202,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	159,377,196.00	96,065,616.50
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)</b>	<b>12,359,683,649.00</b>	<b>14,217,917,011.96</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,359,683,649.00	14,217,917,011.96
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,158,956,768.71	9,434,185,576.50
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	3,494,486,571.36	3,600,491,859.06
210101	Үндсэн цалин	2,132,646,075.04	2,216,029,518.30
210102	Нэмэгдэл	1,122,243,690.96	1,020,908,833.17
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	239,596,805.36	255,773,084.89
210104	Урамшуулал	-	107,780,422.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	463,028,823.59	447,958,021.83
210201	Нийгмийн даатгалын шимтгэл	324,166,925.37	309,491,977.47
210202	Тэтгэмжийн даатгал	35,261,579.95	33,027,260.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	27,624,623.91	26,764,969.35
210204	Ажилгүйдлийн даатгал	12,115,960.73	7,133,997.07
210205	Эрүүл мэндийн даатгал	63,859,733.63	71,539,817.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	187,140,540.17	187,255,298.64
210301	Гэрэл, цахилгаан	76,058,347.79	85,983,072.51
210302	Түлш, халаалт	94,790,390.38	77,525,652.13
210303	Цэвэр, бохир ус	16,291,802.00	23,746,574.00
2104	Хангамж, бараа материалын зардал	166,695,706.80	209,805,785.49
210401	Бичиг хэрэг	53,543,433.94	52,855,439.00
210402	Тээвэр, шатахуун	32,894,200.00	50,830,613.54
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	60,557,743.86	82,684,760.15
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,999,350.00	2,750,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,700,979.00	20,684,972.80
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	30,931,546.30
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	128,102.00
210604	Урсгал засвар	-	30,803,444.30
2107	Томиллолт, зочны зардал	545,489,845.40	1,010,291,042.32
210701	Гадаад албан томиллолт	476,910,849.30	798,045,464.08
210702	Дотоод албан томиллолт	9,779,428.00	5,753,626.15

210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	58,799,568.10	206,491,952.09
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	376,794,552.00	946,937,529.31
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	339,572,497.00	897,444,745.31
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	14,554,400.00	2,374,759.00
210807	Газрын төлбөр	22,667,655.00	47,118,025.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,925,320,729.39	3,000,514,493.55
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,918,080,729.39	2,998,066,593.55
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	7,240,000.00	2,447,900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,200,726,880.29</b>	<b>4,783,731,435.46</b>
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	920,415,378.60	1,758,018,246.39
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	920,415,378.60	1,758,018,246.39
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	389,044,511.12	734,080,001.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	389,044,511.12	734,080,001.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	189,075,602.50	78,969,944.12
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	10,680,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	120,232,992.50	42,828,444.12
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	42,155,410.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	26,687,200.00	25,461,500.00
21310	Засгийн газрын дотоод шилжүүлэг	1,702,191,388.07	2,212,663,243.95
213102	Тусгай зориулалтын шилжүүлэг	1,702,191,388.07	2,212,663,243.95
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)</b>	<b>1,004,949,560.90</b>	<b>845,112,800.24</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>1,004,949,560.90</b>	<b>843,992,800.24</b>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,004,949,560.90	843,992,800.24
223004	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,004,949,560.90	843,992,800.24
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)</b>	<b>(1,004,949,560.90)</b>	<b>(843,992,800.24)</b>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)	-	1,120,000.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	<b>4,246,191.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	<b>5,366,191.00</b>

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

*/төгрөгөөр/*

Үзүүлэлт	Засгийн газрын хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>3,330,370,602.25</b>	<b>895,088,784.63</b>	<b>6,663,483,744.95</b>	<b>10,888,943,131.83</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(58,713,999.78)	(58,713,999.78)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,330,370,602.25	895,088,784.63	6,604,769,745.17	10,830,229,132.05
Тайлант үеийн үр дүн	-	-	(160,090,102.75)	(160,090,102.75)
<b>2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>3,330,370,602.25</b>	<b>895,088,784.63</b>	<b>6,444,679,642.42</b>	<b>10,670,139,029.30</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,330,370,602.25	895,088,784.63	6,444,679,642.42	10,670,139,029.30
Тайлант үеийн үр дүн	-	-	233,479,043.32	233,479,043.32
<b>2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>3,330,370,602.25</b>	<b>895,088,784.63</b>	<b>6,678,158,685.74</b>	<b>10,903,618,072.62</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>15,110,101,700.00</b>	<b>9,201,752,916.90</b>	<b>5,908,348,783.10</b>	<b>60.9</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>15,110,101,700.00</b>	<b>9,201,752,916.90</b>	<b>5,908,348,783.10</b>	<b>60.9</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>11,804,075,400.00</b>	<b>6,952,948,172.95</b>	<b>4,851,127,227.05</b>	<b>58.9</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>3,567,018,500.00</b>	<b>3,551,179,966.49</b>	<b>15,838,533.51</b>	<b>99.5</b>
Үндсэн цалин	2,167,817,600.00	2,166,717,625.73	1,099,974.27	99.5
Нэмэгдэл	1,021,199,400.00	1,020,908,833.17	290,566.83	99.9
Унаа хоолны хөнгөлөлт	270,221,000.00	255,773,084.89	14,447,915.11	94.6
Урамшуулал	107,780,500.00	107,780,422.70	77.30	99.9
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>445,877,300.00</b>	<b>437,666,075.52</b>	<b>8,211,224.48</b>	<b>98.1</b>
Тэтгэврийн даатгал	303,196,600.00	301,531,562.16	1,665,037.84	99.4
Тэтгэмжийн даатгал	35,670,200.00	33,027,260.23	2,642,939.77	92.5
ҮОМШӨ-ний даатгал	28,536,200.00	26,764,969.35	1,771,230.65	93.8
Ажилгүйдлийн даатгал	7,134,000.00	7,133,997.07	2.93	99.9
Эрүүл мэндийн даатгал	71,340,300.00	69,208,286.71	2,132,013.29	97.0
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>303,694,700.00</b>	<b>187,255,298.64</b>	<b>116,439,401.36</b>	<b>61.6</b>
Гэрэл, цахилгаан	109,438,100.00	85,983,072.51	23,455,027.49	78.6
Түлш, халаалт	129,511,900.00	77,525,652.13	51,986,247.87	59.8
Цэвэр, бохир ус	64,744,700.00	23,746,574.00	40,998,126.00	36.7
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>235,251,000.00</b>	<b>203,667,035.49</b>	<b>31,583,964.51</b>	<b>86.6</b>
Бичиг хэрэг	52,102,800.00	52,102,289.00	511.00	99.9
Тээвэр, шатахуун	62,920,000.00	50,830,613.54	12089386.46	80.8
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	97,598,200.00	82,684,760.15	14,913,439.85	84.7
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,330,000.00	2,750,000.00	4580000	37.5
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,300,000.00	15,299,372.80	627.20	99.9
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>310,042,700.00</b>	<b>303,542,355.54</b>	<b>6,500,344.46</b>	<b>97.9</b>
Багаж, техник хэрэгсэл	285,962,100.00	285,903,011.24	59,088.76	99.9
Урсгал засвар	24,080,600.00	17,639,344.30	6,441,255.70	73.3
<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,002,784,600.00</b>	<b>981,902,185.34</b>	<b>20,882,414.66</b>	<b>97.9</b>
Гадаад албан томилолт	780,735,800.00	770,170,999.60	10,564,800.40	98.6
Дотоод албан томилолт	12,399,700.00	5,640,426.15	6,759,273.85	45.5
Зочин төлөөлөгч хүлээн авах	209,649,100.00	206,090,759.59	3,558,340.41	98.3
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,262,999,900.00</b>	<b>905,163,035.38</b>	<b>4,357,836,864.62</b>	<b>17.1</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,996,360,300.00	855,670,251.38	4,140,690,048.62	17.1

Мэдээлэл, технологийн үйлчилгээ	218,478,400.00	2,374,759.00	216,103,641.00	1.0
Газрын төлбөр	48,161,200.00	47,118,025.00	1,043,175.00	97.8
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>676,406,700.00</b>	<b>382,572,220.55</b>	<b>293,834,479.45</b>	<b>56.5</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	673,405,900.00	381,964,320.55	291,441,579.45	56.7
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000,800.00	607,900.00	2,392,900.00	20.2
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,306,026,300.00</b>	<b>2,248,804,743.95</b>	<b>1,057,221,556.05</b>	<b>68.0</b>
Засгийн газрын урсгал шилжүүлэг	3,138,442,300.00	2,212,663,243.95	925,779,056.05	70.5
Засгийн газрын гадаад шилжүүлэг	3,138,442,300.00	2,212,663,243.95	925,779,056.05	70.5
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>167,584,000.00</b>	<b>36,141,500.00</b>	<b>131,442,500.00</b>	<b>21.6</b>
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	16,239,300.00	11,100,000.00	5,139,300.00	68.3
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	122,679,400.00	-	122,679,400.00	-
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28,665,300.00	25,041,500.00	3,623,800.00	87.3
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>15,110,101,700.00</b>	<b>9,201,752,916.90</b>	921,673,439.10	<b>90.9</b>
Улсын төсвөөс санхүүжих	15,110,101,700.00	9,009,713,865.70	1,113,712,490.30	<b>89.0</b>
Төсөвт байгууллагын өөрийн орлого		192,039,051.20	(192,039,051.20)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	4,237,191.00	(4,237,191.00)	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	4,237,191.00	(4,237,191.00)	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
Төсвийн байгууллага	1	1	-	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	147	147	-	100.0
Удирдах ажилтан	10	10	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	123	123	-	100.0
Үйлчлэх ажилтан	14	14	-	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>4,009,599,904.00</b>
УРСГАЛ ЗАРДАЛ		3,368,058,647.91
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>3,325,230,203.79</b>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		49,311,892.57
Үндсэн цалин		49,311,892.57
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		<b>10,291,946.31</b>
Тэтгэврийн даатгал		7,960,415.31
Эрүүл мэндийн даатгал		2,331,531.00
<b>Хангамж, бараа материалын зардал</b>		<b>6,138,750.00</b>
Бичиг хэрэг		753,150.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		5,385,600.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		<b>335,579,584.00</b>
Багаж, техник хэрэгсэл		295,024,054.00
Тавилга		20,791,430.00
Урсгал засвар		19,764,100.00
<b>Томилолт, зочны зардал</b>		<b>28,388,856.98</b>
Гадаад албан томилолт		27,874,464.48
Дотоод албан томилолт		113,200.00
Зочин төлөөлөгч хүлээн авах		401,192.50
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнийн төлбөр, хураамж</b>		<b>82,395,893.93</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		52,589,493.93
Мэдээлэл, технологийн үйлчилгээ		29,806,400.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		<b>2,813,123,280.00</b>
Бараа үйлчилгээний бусад зардал		2,811,283,280.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		1,840,000.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>42,828,444.12</b>
Бусад урсгал шилжүүлэг		42,828,444.12
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		42,828,444.12
Төвлөрүүлэх шилжүүлэг		641,541,256.09
Төвлөрүүлэх шилжүүлэг		641,541,256.09
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>4,009,599,904.00</b>
Нэмэлт санхүүжилтийн орлого		4,009,599,904.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан		992,839,907.50
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан		2,807,491,880.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х		113,202,500.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		96,065,616.50

**Гурав. Аудитын илрүүлэлт:**

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 217,620.5 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад алдааг залрууллаа.

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Бараа материал дансанд 27,770.5 мянган төгрөгийн материалыг бөөн дүнгээр бүртгэсэн, жилийн эцсийн бараа материалын тайлан гаргаж, тооцоо бодоогүй, орлого, зардлын баримтыг хянаж баталгаажуулаагүй байна.	1	27,770.5			1	27,770.5	1	27,770.5				
Оны эцэст нэр бүхий 13 байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулж, гэрээний төлбөрийг урьдчилан шилжүүлснийг шууд зардалд бүртгэсэн.	1	189,850.0	1	189,850.0			1	189,850.0				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>217,620.5</b>	<b>1</b>	<b>189,850.0</b>	<b>1</b>	<b>27,770.5</b>	<b>2</b>	<b>217,620.5</b>				

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 46,250.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд зөрчлийг давтан гаргахгүй байх, зөрчил арилгах 2 зөвлөмж өглөө.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Урьдчилж төлсөн зардал дансанд 2004 онд үүссэн 6,650.0 мянган төгрөгийн үлдэгдэл байна.	1	6,650.0			1	6,650.0						

Гадаад харилцааны яамны 2022 санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Монгол Улсын тухай гэрэл зургийн цомог болон Дилова хутагтын захидал бичиг номыг хэвлүүлэх ажлыг тус бүр 19,800.0 мянган төгрөгөөр шууд гэрээ байгуулан худалдан авч, оны эцэст бөөн дүнгээр зарлагдаж, ажилтан албан хаагч болон бусад хүмүүст олгосон.	1	39,600.0			1	39,600.0			
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>46,250.0</b>			<b>2</b>	<b>46,250.0</b>			

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 1 зөрчил<sup>[1]</sup> илэрснээс шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Үүнээс			Зөвлөмж		
	Тоо	Дүн	Төлбөрийн акт	Албан шаардлага	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсанд 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 24, зарлагын 18 ажил гүйлгээний мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	1	-					1	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>			<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>